



ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮД СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг мэс засал, ажилбаруудын техникийг эзэмшсэн байх, ажлын тайлангаар баталгаажуулах /Кесар мэс засал, умай өндгөвч дайврын хоргүй хавдар, умайн гадуурх жирэмсэн болон умайгаас зангилаа авах зэрэг/;
2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх; /Аймаг, дүүргийн амбулатори, клиник, эрүүл мэндийн төв зэрэгт мэргэшлээрээ ажиллаж байгаа эх барих эмэгтэйчүүдийн эмч өөрөө хүсвэл эмнэлзүйн тохиолдолд суурилсан оношилгоо, эмчилгээний асуудлаар шалгалт өгч болно/;
3. Оношилгоо эмчилгээний шинэ техник, аргачлал 2-оос доошгүйг эзэмшсэн байх /ажлын баталгаажсан тайлан/;
4. Байгууллагынхаа түвшинд оношилгоо, эмчилгээний гарын авлага, зөвлөмж 2-оос доошгүйг боловсруулсан байх /ажлын баталгаажсан тайлан/;
5. Эзэмшсэн мэргэшлээрээ судалгааны ажил 1-2 удаа хийж, онол практикийн хуралд хэлэлцүүлсэн байх;
6. Нийтэд болон үйлчлүүлэгч нарт зориулж мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж, санамж 2-оос доошгүйг бичиж сонин, сэтгүүлд хэвлүүлсэн буюу радио, телевизээр нэвтрүүлсэн байх /сүүлийн 3 жилийн ажлын баталгаажсан тайлан/;
7. Мэргэжлийн холбоо болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцож, сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх /салбар зөвлөлийн даргын тодорхойлолт, гэрчилгээ/.

ТЕРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг мэс засал, ажилбаруудын техникийг эзэмшсэн байх. Үүнд: умайг дайвартай дайваргүй, умайн хүзүүний

- дээгүүр болон бүхэлд нь авах мэс засал, өндгөвчийн уйланхай, хавдар /хүндрэлтэй/ авах, нөхөн сэргээх мэс засал, эсвэл сорвины жирэмсэн, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хийдэг байна. /ажлын баталгаажсан тайлан/;
2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний ур чадварыг эзэмшсэн байх /Аймаг, дүүргийн амбулатори, клиник, эрүүл мэндийн төв зэрэгт мэргэшлээрээ ажиллаж байгаа эх барих эмэгтэйчүүдийн эмч өөрөө хүсвэл эмнэлзүйн тохиолдолд суурилсан оношилгоо, эмчилгээний асуудлаар шалгалт өгч болно/;
 3. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, дотоод шүүрлийн, охидын болон цэвэршилтийн хам шинж, эмгэг цус алдалтыг оношлох эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний ур чадварыг эзэмшсэн байх /ажлын баталгаажсан тайлан/;
 4. Аймаг, дүүрэг, байгууллагын түвшинд оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх чиглэлээр шинэ техник, аргачлал 3-аас доошгүйг эзэмшсэн байх /ажлын баталгаажсан тайлан/;
 5. Аймаг, дүүрэг байгууллагын түвшинд оношилгоо эмчилгээний гарын авлага, зөвлөмж 3-аас доошгүйг боловсруулсан байх /ажлын баталгаажсан тайлан/;
 6. Эзэмшсэн мэргэшлээрээ судалгаа шинжилгээний ажил хийж сүүлийн 5 жилд онол практикийн хуралд 3-аас доошгүй илтгэлийг хэлэлцүүлсэн байх /илтгэлийн хураангуйн хуулбар/;
 7. Шавилан сургалтаар 3-аас доошгүй эмчийг дагалдуулан сургасан байх; /дагалдуулан сургасан эмчийн нэр, сургасан хугацааг тайландаа бичнэ/;
 8. Мэргэжлийн холбоо болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцож сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх /салбар зөвлөлийн даргын тодорхойлолт, гэрчилгээ/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг бүх төрлийн мэс заслуудын техникиг эзэмшсэн байх / ажлын баталгаажсан тайлан/;
2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх / ажлын баталгаажсан тайлан/;
3. Байгууллага, тасаг нэгжийн эрхлэгч эсвэл зөвлөхөөр ажиллаж байгаа болон ажиллаж байсан туршлагатай байх;
4. Үндэсний болон аймаг, дүүрэг, амаржих газарт мөрдэх оношилгоо, эмчилгээний удирдамж, зөвлөмж, ном, гарын авлага 3-аас доошгүйг боловсруулсан байх /ажлын баталгаажсан тайлан/;
5. Үндэсний болон аймаг, дүүрэг, амаржих газрын түвшинд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, стратеги, төсөл, төлөвлөгөө, заавар, журам 3-аас доошгүйг санаачилсан, хамтран боловсруулсан байх /ажлын баталгаажсан тайлан/;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

6. Эзэмшсэн мэргэшлээрээ 4-өөс доошгүй судалгааны ажил хийж онол практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх /илтгэлийн хураангуйн хуулбар/;
7. Тухайн мэргэшлээрээ сургалт семинар, онол практикийн хурал, зөвлөгөөнийг удирдан зохион байгуулсан байх /сүүлийн 5 жилийн ажлын баталгаажсан тайлан/;
8. Өөрийн мэргэжлийн чиглэлээр эмчилгээ, оношилгооны шинэ технологи 4-өөс доошгүйг эзэмшсэн байх;
9. Шавилан сургалтаар 5 ба түүнээс дээш тооны мэргэшлийн эмчийг дагалдуулан сургаж үр дүнд хүргэсэн байх /ажлын баталгаажсан тайлан/;
10. Мэргэжлийн холбоо болон салбар зөвлөлийн ажилд идэвхи санаачлагатай оролцож сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх /салбар зөвлөлийн даргын тодорхойлолт, гэрчилгээ/.